

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/094/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.24 № 362
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ ТОСГОНЫ
ЗАХИРАГЧ Д.АЛТАННАРАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Халаалтын улирлын эхлэх, дуусах хугацааг баримталж ажиллаагүй, халаалтын төлбөрийг 7,654.6 мянган төгрөгөөр илүү төлж, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан, төрийн захиргааны албан тушаал болох Хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр шаардлага хангаагүй иргэнийг томилсон, санхүүгийн албаны даргын албан үүргийг нягтлан бодогчид хавсруулан гүйцэтгүүлсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 583,288.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, 509,438.7 мянган төгрөгийг зарцуулж, 73,849.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд 4,506.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 3,600.0 мянган төгрөгийг зарцуулж, 909.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 19,183.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 820.1 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, халаалтын улирлын эхлэх, дуусах хугацааг баримталж ажиллаагүй, халаалтын төлбөрийг 7,654.6 мянган төгрөгөөр илүү төлж, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан, төрийн захиргааны албан тушаал болох Хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр шаардлага хангаагүй иргэнийг томилсон, санхүүгийн албаны даргын албан үүргийг нягтлан бодогчид хавсруулан гүйцэтгүүлж 10,708.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжилт 90 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээш түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>67,242,584.24</u>	<u>100,562,501.00</u>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	184,839.24	906,326.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	184,839.24	
335	Бусад авлага	-	906,326.00
3351	Байгууллагаас авах авлага		906,326.00
35	БАРАА МАТЕРИАЛ	67,057,745.00	99,656,175.00
354	Хангамжийн материал	67,057,745.00	99,656,175.00
35410	Бичиг хэргийн материал	2,614,800.00	1,890,900.00
35420	Аж ахуйн материал	14,252,170.00	48,214,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	535,000.00	535,000.00
35440	Түлш, шатах тослох материал	640,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	49,015,775.00	49,015,775.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,360,896,577.78</u>	<u>1,440,381,327.89</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>1,360,896,577.78</u>	<u>1,440,381,327.89</u>
392	Биет хөрөнгө	<u>1,304,501,577.78</u>	<u>1,384,001,327.89</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,217,350,178.00	1,506,352,169.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(222,538,816.02)	(357,329,359.53)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	134,600,000.00	134,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49,746,666.44)	(71,239,999.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,133,977.00	184,133,977.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(108,743,490.81)	(136,026,866.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,745,180.00	65,745,180.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,693,680.64)	(41,082,180.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	238,749,001.00	238,749,001.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(123,354,104.31)	(139,900,592.43)
393	Биет бус хөрөнгө	<u>56,395,000.00</u>	<u>56,380,000.00</u>
39301	Програм хангамж	930,000.00	930,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(425,000.00)	(440,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	55,890,000.00	55,890,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,428,139,162.02</u>	<u>1,540,943,828.89</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>8,872,750.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	8,872,750.00
413	Өглөг	-	<u>8,872,750.00</u>
4136	Бусад өглөг	-	<u>8,872,750.00</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	8,872,750.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,428,139,162.02</u>	<u>1,532,071,078.89</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>1,428,139,162.02</u>	<u>1,532,071,078.89</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	150,057,831.00	150,057,831.00
51101	Өмч: - төрийн	150,057,831.00	150,057,831.00
512	Хуримтлагдсан үр дүн	<u>1,171,249,088.04</u>	<u>1,275,181,004.91</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,171,249,088.04	1,171,249,088.04
51220	Тайлант үеийн үр дүн	-	103,931,916.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	106,832,242.98	106,832,242.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,428,139,162.02</u>	<u>1,540,943,828.89</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	914,403,543.00	910,421,217.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	404,380,456.00	322,626,491.00
120	Нийтлэг татварын бус орлого	404,380,456.00	322,626,491.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	404,380,456.00	322,626,491.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	404,210,456.00	322,626,491.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	510,023,087.00	587,794,726.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,734,787.00	4,506,326.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,092,099.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,734,787.00	414,227.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	506,288,300.00	583,288,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	506,288,300.00	583,288,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	629,101,754.61	806,489,300.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	629,101,754.61	806,489,300.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	479,083,131.99	724,389,565.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,662,003.00	340,566,500.71
210101	Үндсэн цалин	166,931,861.00	183,627,708.02
210102	Нэмэгдэл	63,352,535.00	119,344,062.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	988,000.00	5,710,000.00
210104	Урамшуулал	3,825,200.00	664,484.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,564,407.00	31,220,246.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,070,801.09	42,301,277.01
210201	Тэтгэврийн даатгал	21,606,396.69	28,875,906.39
210202	Тэтгэмжийн даатгал	2,417,575.21	3,153,607.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,487,414.72	2,471,609.43
210204	Ажилгүйдлийн даатгал	1,103,962.05	1,969,679.91
210205	Эрүүл мэндийн даатгал	4,455,452.42	5,830,474.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,097,827.25	75,141,991.48
210301	Гэрэл, цахилгаан	7,929,905.15	11,096,197.78
210302	Түлш, халаалт	28,167,922.10	64,045,793.70
2104	Хангамж, бараа материалын зардал	30,035,437.00	23,353,810.00
210401	Бичиг хэрэг	1,478,600.00	4,353,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,665,047.00	11,819,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,081,000.00	3,740,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,810,790.00	3,440,780.00
2105	Нормативт зардал	1,150,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,150,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,861,400.00	11,346,540.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,737,000.00
210604	Урсгал засвар	6,861,400.00	9,609,540.00
2107	Томилолт, зочны зардал	7,035,000.00	7,330,000.00
210702	Дотоод албан томилолт	7,035,000.00	7,330,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,194,787.00	1,874,205.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,623,287.00	1,499,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,500.00	149,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	176,000.00
210807	Газрын төлбөр	-	50,005.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,975,876.65	222,475,240.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,367,470.00	7,958,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,528,406.65	214,517,240.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,018,622.62	82,099,735.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,600,000.00	8,250,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	8,250,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	138,418,622.62	73,849,735.04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	138,418,622.62	73,849,735.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>285,301,788.39</u>	<u>103,931,916.87</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>285,301,788.39</u>	<u>103,931,916.87</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>510,193,087.00</u>	<u>587,794,726.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	170,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	170,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	170,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	510,023,087.00	587,794,726.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,734,787.00	4,506,326.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,092,099.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,734,787.00	414,227.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	506,288,300.00	583,288,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	506,288,300.00	583,288,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>510,193,087.00</u>	<u>587,794,726.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	510,193,087.00	587,794,726.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	360,074,464.38	504,623,664.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,561,723.00	340,781,663.02
210101	Үндсэн цалин	154,019,219.00	197,865,515.02
210102	Нэмэгдэл	68,428,098.00	115,802,764.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,404,000.00	11,995,000.00

210104	Урамшуулал	8,437,202.00	1,374,165.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,273,204.00	13,744,219.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,360,240.13	42,301,275.46
210201	Тэтгэврийн даатгал	21,250,877.13	28,436,936.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,417,575.21	3,313,043.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,624,745.32	2,164,450.75
210204	Ажилгүйдлийн даатгал	1,205,487.65	1,632,239.66
210205	Эрүүл мэндийн даатгал	4,861,554.82	6,754,605.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,090,677.25	74,065,431.48
210301	Гэрэл, цахилгаан	7,929,905.15	11,096,197.78
210302	Түлш, халаалт	27,160,772.10	62,969,233.70
2104	Хангамж, бараа материалын зардал	24,561,437.00	14,291,300.00
210401	Бичиг хэрэг	3,043,300.00	2,317,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,806,447.00	6,984,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,092,000.00	3,740,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,703,400.00	339,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,916,290.00	910,500.00
2105	Нормативт зардал	200,000.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,372,100.00	5,392,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	450,000.00	769,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	714,900.00
210604	Урсгал засвар	5,922,100.00	3,908,750.00
2107	Томилолт, зочны зардал	6,935,000.00	7,330,000.00
210702	Дотоод албан томилолт	6,935,000.00	7,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,410,787.00	7,760,945.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,604,287.00	7,385,940.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,500.00	149,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	670,000.00	176,000.00
210807	Газрын төлбөр	-	50,005.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,582,500.00	12,400,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,672,500.00	11,774,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	910,000.00	626,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,118,622.62	83,171,061.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,700,000.00	8,415,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	8,250,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,100,000.00	165,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	138,418,622.62	74,756,061.04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	138,418,622.62	73,849,735.04
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		906,326.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,057,831.00	106,832,242.98	885,947,299.65	1,142,837,373.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,057,831.00	106,832,242.98	885,947,299.65	1,142,837,373.63
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	0	0
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	0	0
C07	Тайлант үеийн үр дүн	0	0	285,301,788.39	285,301,788.39
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,057,831.00	106,832,242.98	1,171,249,088.04	1,428,139,162.02
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	150,057,831.00	106,832,242.98	1,171,249,088.04	1,428,139,162.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,057,831.00	106,832,242.98	1,171,249,088.04	1,428,139,162.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	103,931,916.87	103,931,916.87
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,057,831.00	106,832,242.98	1,275,181,004.91	1,532,071,078.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	583,288,400.00	509,438,664.96	73,849,735.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	583,288,400.00	509,438,664.96	73,849,735.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	573,455,400.00	501,023,664.96	72,431,735.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	400,284,700.00	340,781,663.02	59,503,036.98
210101	Үндсэн цалин	261,960,300.00	197,865,515.02	64,094,784.98
210102	Нэмэгдэл	51,885,600.00	115,802,764.00	(63,917,164.00)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,960,000.00	11,995,000.00	(8,035,000.00)
210104	Урамшуулал	18,000,000.00	1,374,165.00	16,625,835.00
210105	Гэрээт ажлын хөлс	64,478,800.00	13,744,219.00	50,734,581.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,035,500.00	42,301,275.46	7,734,224.54

210201	Тэтгэврийн даатгал	34,024,200.00	28,436,936.54	5,587,263.46
210202	Тэтгэмжийн даатгал	4,002,800.00	3,313,043.07	689,756.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,001,400.00	2,164,450.75	(163,050.75)
210204	Ажилгүйдлийн даатгал	2,001,400.00	1,632,239.66	369,160.34
210205	Эрүүл мэндийн даатгал	8,005,700.00	6,754,605.44	1,251,094.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,925,800.00	74,065,431.48	(14,139,631.48)
210301	Гэрэл, цахилгаан	7,143,600.00	11,096,197.78	(3,952,597.78)
210302	Түлш, халаалт	51,582,200.00	62,969,233.70	(11,387,033.70)
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	-	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,092,000.00	14,291,300.00	1,800,700.00
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,317,300.00	182,700.00
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.00	6,984,500.00	1,015,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,092,000.00	3,740,000.00	352,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	550,000.00	339,000.00	211,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950,000.00	910,500.00	39,500.00
2105	Нормативт зардал	900,000.00	300,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900,000.00	300,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,125,200.00	5,392,650.00	2,732,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,585,200.00	769,000.00	1,816,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	540,000.00	714,900.00	(174,900.00)
210604	Урсгал засвар	5,000,000.00	3,908,750.00	1,091,250.00
2107	Томилолт, зочны зардал	8,000,000.00	7,330,000.00	670,000.00
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	7,330,000.00	670,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,392,100.00	7,760,945.00	7,631,155.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,132,900.00	7,385,940.00	5,746,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,200.00	-	324,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	-	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	149,000.00	101,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	145,000.00	-	145,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	176,000.00	264,000.00
210807	Газрын төлбөр	550,000.00	50,005.00	499,995.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,700,100.00	8,800,400.00	5,899,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,750,100.00	8,174,400.00	5,575,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	950,000.00	626,000.00	324,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,833,000.00	8,415,000.00	1,418,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,833,000.00	8,415,000.00	1,418,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,250,000.00	8,250,000.00	-

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,583,000.00	165,000.00	1,418,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	583,288,400.00	509,438,664.96	73,849,735.04
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	583,288,400.00	509,438,664.96	73,849,735.04
132001	Орон нутгийн төсвөөс	583,288,400.00	509,438,664.96	73,849,735.04
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	15	15	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	
650010	Гэрээт ажилтан	1	1	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,506,326.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,506,326.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,600,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	906,326.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	906,326.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,506,326.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,506,326.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,092,099.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	414,227.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар 820.1 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд:
Залруулсан алдаа:

1. Санхүүгийн тайланд санхүүжилтийн орлого болон төвлөрүүлсэн шилжүүлгийг 820.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн алдааг залрууллаа.

Аудитаар илэрсэн 18,363.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

3.1 Төлбөрийн акт Байхгүй.

3.2 Албан шаардлага

1. Халаалтын улирлын эхлэх, дуусах хугацааг баримталж ажиллаагүй, халаалтын төлбөрийг 7,654.0 мянган төгрөгөөр илүү төлсөн нь Эрчим хүчний сайдын 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан “Халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох тухай” тушаалын 1.в-д Сүхбаатар, Хэнтий, Ховд, Говьсүмбэр аймгуудын төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаанаар хангагддаг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууцны халаалтын эхлэх хугацааг тухайн оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөр,

дуусах хугацааг дараа оны 5 дугаар сарын 15-ны өдрөөр, бусад аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын эхлэх хугацааг 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг 5 дугаар сарын 01-ний өдрөөр” гэснийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Төрийн захиргааны албан тушаал болох Хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр шаардлага хангаагүй иргэнийг томилж 4,189.3 мянган төгрөгийн, Санхүүгийн албаны даргын албан үүргийг нягтлан бодогчид хавсруулан цалингийн 40 хувь 6,519.5 мянган төгрөгийн, нийт 10,708.8 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 43.3."Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг дараахь журмаар түр орлон гүйцэтгүүлнэ: ...", 43.6. "Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж Байхгүй

Аудитаар нийт 18,363.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинээс өндөр тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаг даагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
санхүүжилтийн орлого, төвлөрүүлсэн шилжүүлгийг илүү тусгасан	1	820.1			1	820.1	1	820.1				
Дүн	1	820.1			1	820.1	1	820.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
халаалтын хугацааг баримтлаагүй, төлбөр илүү төлсөн	1	7,654.6			1	7,654.6						
Төрийн захиргааны албан тушаал түр орлон гүйцэтгүүлсэн	1	10,708.8			1	10,708.8						
Дүн	2	18,363.4			2	18,363.4						

5. АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 70-А 2370447

Чингис хот

ХЭА - 2026/094/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн захиргааны албан тушаал болох Хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр шаардлага хангаагүй иргэнийг томилж 4,189,300 төгрөгийн, Санхүүгийн албаны даргын албан үүргийг нягтлан бодогчид хавсруулж цалингийн 40 хувь буюу 6,519,454 төгрөгийн, нийт 10,708,754.00 (арван сая долоон зуун найман мянга долоон зуун тавин дөрвөн) төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 43.3."Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг дараах журмаар түр орлон гүйцэтгүүлнэ: ...", 43.6. "Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно" гэснийг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төрийн захиргааны албан тушаалыг шаардлага хангаагүй иргэн, ажилтнаар түр орлон, хавсруулан гүйцэтгүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирагч Д.Алтаннараад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Н.ТУЯА



Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймагийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 69-А2370447

Чингис хот

ХЭА-2026/094/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Халаалтын улирлын эхлэх, дуусах хугацааг баримталж ажиллаагүй, халаалтын төлбөрийг 7,654,604.00 (долоон сая зургаан зуун тавин дөрвөн мянга зургаан зуун дөрвөн) төгрөгөөр илүү төлсөн.

Энэ нь Эрчим хүчний сайдын 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан "Халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох тухай" тушаалын 1.в-д Сүхбаатар, Хэнтий, Ховд, Говьсүмбэр аймгуудын төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаанаар хангагддаг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууцны халаалтын эхлэх хугацааг тухайн оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 5 дугаар сарын 15-ны өдрөөр, бусад аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын эхлэх хугацааг 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг 5 дугаар сарын 01-ний өдрөөр" гэснийг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй;" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Халаалтын улирлын эхлэх, дуусах хугацааг тогтоосон шийдвэрийг баримталдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирагч Д.Алтаннараад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Н.ТУЯА

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112